ИЛ БОЛСОН

МАШ НУУЦ



БАТЛАВ:
“БЕСТ ШҮЕС” ХХК-ИЙН ЗАХИРАЛ

/ Б. ТҮВДЭННЯМ /

БАТЛАВ:
“ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ”ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

/ Н.УДААНЖАРГАЛ /

**ХУДАЛДАХ, ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭ**

**2022 оны 09 -р сарын 21 өдөр** **№ ТТЗ-МН22/09** **Улаанбаатар хот**

**Нэг талаас**: Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс гудамж 92 тоот байранд байрлах, 2647923 тоот регистрийн дугаар бүхий “БЕСТ ШҮЕС” ХХК ***/цаашид “Худалдагч” гэх/*** түүнийг төлөөлж Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга Д.Уранзул
**Нөгөө талаас**: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол /14230/, Нарны зам-62 Юнион Бюлдинг, Б блок 11 давхар, 6375405 регистрийн дугаар бүхий “ТАВАНТОЛГОЙ ТӨМӨР ЗАМ” ХХК ***/цаашид “Худалдан авагч” гэх/*** түүнийг төлөөлж Захиргаа удирдлагын газрын дарга Я.Намсрай ***/цаашид хамтад нь “Талууд” гэх/*** Иргэний хуулийн 243-261 дүгээр зүйлүүдийг үндэслэн дараах нөхцөлтэйгөөр харилцан тохиролцож байгуулав.

## *Нэг.* **Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү Гэрээгээр Худалдагч нь Худалдан авагчийн захиалгын дагуу Хавсралт № 01-д заасан биет байдлын болон эрхийн доголдолгүй ажлын гутлыг /цаашид “Бараа” гэх /, түүнтэй холбоотой баримт бичгийн хамт худалдан авагчийн өмчлөлд шилжүүлэх,худалдан авагч нь барааг шалган хүлээн авч, гэрээнд заасан хугацаанд төлбөрийг шилжүүлэхтэй холбоотой Талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Барааны нэг бүрийн үнэ, too ширхэг, нийт үнэ:

- 241180592 кодтой үдээстэй өвлийн хөдөлмөр хамгааллын гутал нэг бүр 188,000 /нэг зуун наян найман мянган/ төгрөг, нийт 371 ширхэг.
- 241150602 кодтой угалдаг өвлийн хөдөлмөр хамгааллын гутал гутал 195,000 /нэг зуун наян найман мянган/ төгрөг, нийт 9 ширхэг.
- 241180592, 241150602 код бүхий нийт 380 ширхэг ажлын гутал, нийт үнэ 71,503,000 /далан нэгэн сая таван зуун гурван мянган/ төгрөг.

1.3. 1.2-д заасан үнэд ***[НӨАТ орсон]*** болно.
1.4. Талуудын аль нэг хуулийн этгээдийн хувьд өөрчлөн байгуулагдсан нь энэхүү гэрээг цуцлах болон үүргээ биелүүлэхгүй байх үндэслэл болохгүй.
1.5. Талууд харилцан тохиролцон гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлтийг бичгээр үйлдэж талууд гарын үсэг зурна.
1.6. Талуудын аль нэг нь нөгөө талын зөвшөөрөлгүйгээр гэрээний эрх үүргээ гуравдагч этгээдэд шилжүүлэхийг хориглоно.

## *Хоёр.* **Бараа нийлүүлэх хугацаа**

2.1. Бараа нийлүүлэх хугацаа: 2022.10,15-ны дотор Худалдан авагчийн заасан Улаанбаатар хот доторх агуулахад нийлүүлнэ.

ИЛ БОЛСОН
МАШ НУУЦ


## *Гурав.* **Барааны чанар, төрөл**

3.1. Худалдагчаас нийлүүлж байгаа бараа нь чанар, стандартын шаардлагыг хангасан, Худалдан авагчид урьдчилан танилцуулсны дагуу байна.

3.2. Худалдан авагч гэрээний дагуу нийлүүлсэн барааг шалгаж авна. Худалдаж авсан барааг шалгах болон ашиглах явцад илэрсэн доголдлыг худалдагч талд доголдол илэрсэн өдрөөс хойш ажлын 7 хоногийн дотор мэдэгдэнэ.

3.3. Барааны код: 241180582, 241150602 /ажлын гутал/

3.4. Барааны чанарын баталгаа: 3 сар

## *Дөрөв.* **Төлбөрийн нөхцөл**

4.1. Урьдчилгаа төлбөр 50 хувийг гэрээ батлагдсанаас хойш ажлын 5 хоногт, үлдэгдэл төлбөр 50 хувийг бүтээгдэхүүн нийлүүлж дууссаны дараа ажлын 5 хоногт Худалдагч талын **Капитрон банкны 3053000898** тоот **БЕСТ ШҮЕС** гэсэн дансанд шилжүүлнэ.

## *Тав.* **Худалдагчийн эдлэх эрх , хүлээх үүрэг**

5.1. Худалдагч нь дараах эрхийг эдэлнэ.Үүнд:

5.1.1 Худалдагч нь Худалдан авагчийн захиалсан захиалгын дагуу барааг шалган хүлээн авахыг Худалдан авагчаас шаардах эрхтэй;

5.1.2 Нийлүүлсэн барааны үнийг гэрээний хугацаанд төлж барагдуулахыг шаардах эрхтэй.

5.2. Худалдагч нь дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

5.2.1. Худалдан авагчийн захиалсан барааг гэрээний хугацаанд нийлүүлнэ;

5.2.2. Барааг тээвэрлэхээс ажлын 1 хоногийн өмнө утсаар худалдан авагчид бараа нийлүүлэх талаар мэдэгдэнэ;

5.2.3. Худалдан авагчийн шаардлагаар чанарын доголдолтой барааг буцаан авч шаардлага хангасан шинэ бараагаар сольж өгнө;

5.2.4. Барааг өөрийн зардлаар Худалдан авагчийн заасан Улаанбаатар хот доторх агуулахад хүргэж өгнө;

5.2.5. Худалдан авагчийг барааны түүхийн эдийн чанар, стандартын талаарх үнэн зөв мэдээллээр хангана;

5.2.6. Энэхүү гэрээг байгуулсан Худалдан авагч талын бизнесийн үйл ажиллагаатай холбоотой аливаа мэдээллийг шууд буюу шууд бусаар бусдад задруулахгүй байх, гэрээнд зааснаас өөрөөр ашиглахгүй байх үүрэгтэй.

## *Зургаа.* **Худалдан авагчийн эдлэх эрх, хүлээх үүрэг**

6.1. Худалдан авагч нь дараах эрхийг эдэлнэ.Үүнд:

6.1.1. Худалдан авагч нь захиалсан барааны доголдлыг арилгуулах буюу доголдолгүй ижил төрлийн бараагаар солиулан авах эрхтэй;

6.1.2. Худалдагчийг гэрээнд заасан хугацаанд бараагаа нийлүүлэхийг шаардах эрхтэй;

6.1.3. Барааг хүлээлцэхэд чанар, стандартын шаардлага хангахааргүй байвал хүлээж авахаас татгалзах эрхтэй;

6.2. Худалдан авагч дараах үүрэг хүлээнэ. Үүнд:

6.2.1. Худалдагчаас барааг нийлүүлэх хугацааг мэдэгдсэнээс хойш ажлын 1 хоногийн дотор барааг хүлээж авах бэлтгэлийг хангасан байна;

6.2.2. Барааг хүлээж авахдаа тоо, чанар, иж бүрдлийг шалгаж, акт үйлдэж зохих бичиг баримтыг бүрдүүлнэ;

ИЛ БОЛСОН
МАШ НУУЦ


6.2.3 Худалдан авагч нь гэрээний 4.1 заасан хугацаанд хуваарийн дагуу төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд нийт үнийн дүнгийн 0,5 хувийн алдангийг Худалдагч талд төлнө.

*Долоо.* **Талуудын хариуцлага**

7.1. Барааны эдэлгээний баталгаат хугацаа 3 сар байх бөгөөд эдэлгээний хугацаанаас өмнө үйлдвэрлэлийн гэмтэлтэй барааг худалдагч талд мэдэгдсэнээс хойш ажлын 14 хоногийн дотор шинэ бараагаар сольж өгнө.

7.2. Гэрээ баталгаажсанаас хойш барааны загвар болон үнэд өөрчлөлт оруулахгүй болно.

*Найм.* **Давагдашгүй хүчин зүйл**

8.1. Энэхүү гэрээг байгуулсны дараа давагдашгүй хүчин зүйл (тухайлбал: үер, гал түймэр, газар хөдлөлт, халдварт өвчний тархалт, зэвсэгт мөргөлдөөн, террорист үйлдэл, иргэдийн үймээн, ажил хаялт, төрийн шийдвэр оролцоо гэх мэт)-ийн нөхцөл байдлын шууд болон шууд бус үйлчлэлийн улмаас аль нэг тал болон талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэх боломжгүй тохиолдолд гэрээний үйлчлэх хугацааг тухайн нөхцөл байдлыг арилах хүртэл хойшлуулж болно.

8.2. Гэрээний үүргийг биелүүлэхэд саад болох нөхцөл байдал үүссэн, дууссан тухай талууд нэн даруй нэг нэгэндээ бичгээр мэдэгдэнэ.

8.3. Давагдашгүй хүчин зүйл болсон гэдгийг эрх бүхий байгууллага нотолно.

*Ес.* **Маргааныг шийдвэрлэх**

9.1. Гэрээтэй холбоотой маргааныг талууд харилцан тохиролцох замаар шийдвэрлэнэ.

9.2. Талууд тохиролцоонд хүрч чадахгүй бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу маргааныг шүүхээр шийдвэрлүүлнэ.

*Арав.* **Гэрээний үйлчлэх хугацаа**

10.1. Гэрээний үйлчлэх хугацааг хоёр тал харилцан тохиролцож сунгаж болно.

10.2. Энэхүү гэрээг хугацаанаас нь өмнө дараах үндэслэлүүдээр цуцалж болно.Үүнд:

10.2.1. Гэрээгээр тогтоосон хугацааны дотор худалдан авагч төлбөрөө төлөөгүй нөхцөлд, түүнчлэн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нийлүүлэлт хийх боломжгүй болсон тухайгаа худалдан авагчид албан ёсоор мэдэгдсэн тохиолдолд худалдагчийн санаачлагчаар хугацаанаас өмнө цуцалж болно.

10.2.2. Худалдан авагч барааг үргэлжлүүлэн худалдан авахаас татгалзсан тухайгаа худалдагчид албан ёсоор бичгээр мэдэгдэж тооцоо нийлэн, барааны төлбөрөө бүрэн төлж барагдуулсан тохиолдолд худалдан авагчийн санаачилгаар гэрээг хугацаанаас өмнө цуцалж болно.

10.2.3. Давагдашгүй хүчин зүйлийн үйлчлэлээр

*Арван нэг.* **Бусад заалт**

11.1. Гэрээг хоёр хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгална.

11.2. Талууд гэрээнд тусгагдаагүй асуудлыг шийдвэрлэхдээ Монгол улсын иргэний хууль болон холбогдох хууль тогтоомжийг мөрдлөг болгоно.

11.3. Энэхүү гэрээнд талуудын эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болно.

ИЛ БОЛСОН МАШ НУУЦ



11.4. Талууд энэхүү гэрээг байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдуулан мөнгөн буюу мөнгөн бус хэлбэрээр шагнал, шан харамж, урамшуулал зэрэг гэрээнд тусгагдаагүй аливаа төлбөрийг харилцан төлөөгүй болно.

11.5. Худалдагч тал нь Худалдан авагчийн Бизнесийн ёс зүйн дүрэмтэй танилцсан бөгөөд тус дүрмийг дагаж мөрдөнө.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

**ХУДАЛДАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Захиргаа хүний нөөцийн хэлтсийн дарга
Д.Уранзул

Хаяг:
Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс гудамж 92-р байр
Утас: 7000-6670, 8808-1668

**ХУДАЛДАН АВАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

Захиргаа удирдлагын газрын дарга
Я.Намсрай

Хаяг:
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, 13-р хороолол /14230/, Нарны зам-62 Юнион Бюлдинг, Б блок 11 давхар

Утас: 7777-7727

**№ _______________ ТООТ ХУДАЛДАХ,ХУДАЛДАН АВАХ ГЭРЭЭНИЙ**

**ХАВСРАЛТ № 01**

**Гутлын размерын задаргаа**

| **Код** | **35** | **36** | **37** | **38** | **39** | **40** | **41** | **42** | **43** | **44** | **45** | **46** | **Нийт тоо ширхэг** |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 241180582 ***өвөл*** | **5** | **30** | **35** | **25** | **38** | **58** | **70** | **78** | **23** | **5** | **4** | | **371** |
| 241150602 ***өвөл*** | | | | **1** | **2** | **2** | **1** | **1** | **2** | | | | **9** |

**Гэрээ байгуулсан:**

Худалдагчийг төлөөлж:

________________Д.Уранзул / ЗУХНХ-ын дарга /

Худалдан авагчийг төлөөлж:

_______________/ Захиргаа удирдлагын газрын дарга Я.Намсрай

6

СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР

# ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ

*Дугаар:* **УБД0002171**

**СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ГАЗАР**

*Баталгаажуулалтын байгууллагын нэр*

**Аж ахуйн нэгж, байгууллага/иргэн:**

Нэр: **БЕСТ ШҮЕС ХХК**

Утас/Факс: **86081668**

И-мэйл: **mon_bestshoes@yahoo.com**

Хаяг: **БГД, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүсийн гудамж, 92-р байр**

**Энэхүү гэрчилгээг олгоход үндэслэсэн баримт, бичгүүд:**

1. Сорилтын дүнгийн дугаар, огноо: **2021.02.10-ны өдрийн 2021-53**
2. Сорилт хийсэн итгэмжлэгдсэн лабораторийн нэр: **Судалгаа хөгжлийн төвийн итгэмжлэгдсэн лаборатори**
3. Удирдлагын тогтолцооны нэр, гэрчилгээний дугаар, олгосон байгууллагын нэр:

**СХЗГ-ын Бүтээгдэхүүний Баталгаажуулалтын Зөвлөлийн 2021.04.30-ны өдрийн 04/21 тоот хурлын тэмдэглэл**

**Бүтээгдэхүүн үйлчилгээний тодорхойлолт:**

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **Ажлын гутал болон гоёлын гутал** | **6405** | **MNS 0078:1988, MNS 5623:2006** |

*Дээрхи бүтээгдэхүүн үйлчилгээ нь холбогдох стандарт, норматив техникийн баримт бичиг (НТББ)-ийн шаардлагыг хангаж байгаа тул энэхүү ГЭРЧИЛГЭЭ-г олгов.*

**В. ГАНЗОРИГ** — *Гарын үсэг/нэр*

**С.Алтанцэцэг** — *Гарын үсэг/нэр*

**2021-04-30**

*Олгосон огноо*

**2024-04-29**

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

# БАТЛАМЖ

№ 871

**БЭСТ ШҮЕС ХХК**

/Иргэн, аж ахуйн нэгжийн нэр/

Худалдаа, үйлчилгээг зохицуулах зөвлөлтэй байгуулсан 2020 оны 08... дугаар сарын 26.. -ны өдрийн .871...... дугаар гэрээг үндэслэн тус дүүргийн 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх "БАТЛАМЖ" олгов.

Үйл ажиллагааны чиглэл ............ Гутал үйлдвэрлэл

Аж ахуйн нэгж, иргэний регистрийн дугаар ............ РД: 2647923

Үйл ажиллагаа явуулж буй байршил ............ 20-р хороо, Үйлдвэрийн бүс гудамж, 92-р байр

Холбогдох утасны дугаар: /цахим хаяг/ ............ 99111144

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХҮНС, ХУДАЛДАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА

........ /Э.САНСАР/

/Гарын үсэг/

ХҮЧИНТЭЙ ХУГАЦАА

20.20. оны 08. сарын 03

20.21. оны 08. сарын ...

УЛААНБААТАР ХОТ

*Хятад хэлнээс Монгол хэл руу орчуулав.*

ЮНИОН ТЕХНОЛОГИЙН ТУРШИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

Утас: 86-769-85815150 шинжилгээний бичиг Факс: 86-769-85815376

Шинжилгээний бичгийн код: UNION311P06

Дараах хаяг руу нууц кодоор нэвтрэн орж лавлана уу.

Итгэмжлэгч : Гуан жоу Жиа чуан гутлын материал

Хаяг : Гуан жоу хот ян вань дүүрэг хотын баруун зам 91 –р баруун ши чөн гутлын материалын зах 3 давхар 2334В өрөө

Үйлдвэрлэгч :

Хаяг :

Дээжийн нэр: SWATOO1 42размерын хар өнгийн резинэн гутлын ул

Тайлбар :

Хариу гарсан огноо: 2018 оны 12 сарын 15 өдөр

Хүлээж авсан огноо: 2018 оны 12 сарын 11 өдөр

Туршилт хийсэн огноо : 2018 оны 12 сарын 11 өдөр

Итгэмжлэлийн дугаар : C07-12103

Сорьцын тоо: 1 ширхэг

| Туршилтын үзүүлэлт | Үр дүн | Итгэмжлэгчийн шаардлага | Туршилтын нөхцөл |
|---|---|---|---|
| Хүйтэнд тэсвэрлэх нумрах хугарах туршилт | 50000 удаа нугалж эргүүлсэний дараа ямар ч ором гараагүй | | 1-70 $^{0}$C<br>2 90$^{0}$C [illegible]<br>[illegible] |

Лабраторийн эрхлэгч :\ гарын үсэг, тусгай тамгатай\

**"ЧАМИН ӨНГӨ"** Баталгаат орчуулгын товчоо
Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг 4-р хороо
***"SILVER"** бизнес төвийн 11 тоот*

*Утас: 89443883*
*И_мэйл: chaminungu11@gmail.com*
*Орчуулагч:Б.Настмандарнаа*
*Огноо:2020-04-29*

Хятад хэлнээс Монгол хэл руу орчуулав.

ЮНИОН ТЕХНОЛОГИЙН ТУРШИЛТ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТӨВ

Утас: 86-769-85815150 шинжилгээний бичиг Факс: 86-769-85815376

**Дээжинд илгээсэн дээжийн карт :**

Огноо : 2018 оны 12 сарын 15 өдөр Итгэмжлэлийн дугаар : C07-12103

Зураг

Тайлбар : дээжийн карт нь шинжилгээнд хамт хэрэглэгдэх ёстой .

Лабраторийн эрхлэгч :\ гарын үсэг, тусгай тамгатай\

Англи хэлнээс хөрвүүлэв

**INTERTEK** /Лого/ /Лого/ /Лого/

Бүх чанар баталгаажсан

## ТУРШИЛТЫН ТАЙЛАН

GZHT91006863(SD)

Туршилтыг хүсэлт гаргагчийн хүсэлтийг дагуу гүйцэтгэв

1 Металл бус нэвтрэлтэд тэсвэртэй оруулганы дулааны насжилтын туршилтын дараа хадаас нэвтрэлтэд тэсвэртэй байдал (EN 12568:2010, 7.2.1 & 7.4.2)

| Өндөр температурын нөлөө. (60°C x 4 цаг, дараа нь 45 °c x 18 цаг) | | | | |
|---|---|---|---|---|
| Дээж | Дээж | Хариу | Шаардлага | Тэнцсэн/ тэнцээгүй |
| - | Дээж 1 | 1,100 Н-д хадаас нэвтрээгүй ба 1,100 Н-д давхаргууд нь салаагүй | * | Тэнцсэн |
| | Дээж 2 | 1,100 Н-д хадаас нэвтрээгүй ба 1,100 Н-д давхаргууд нь салаагүй | * | Тэнцсэн |

Тэмдэглэгээ: * =туршилтын хадаасны үзүүр нь туршилтын хэсгийг нэвтэрч чадаагүй бөгөөд 1,100 Н-д давхаргууд нь салаагүй

2 Металл бус нэвтрэлтэд тэсвэртэй оруулганы дулааны насжилтын туршилтын дараа ха... тэсвэртэй байдал (EN 12568:2010, 7.2.1 & 7.4.3

| Бага температурын нөлөөлөл. (-20° c x 4 цаг, дараа нь -6° c x 18 цаг) | | | | |
|---|---|---|---|---|
| Дээж | Дээж | Хариу | Шаардлага | Тэнцсэн/ тэнцээгүй |
| - | Дээж 1 | 1,100 Н-д хадаас нэвтрээгүй ба 1,100 Н-д давхаргууд нь салаагүй | * | Тэнцсэн |
| | Дээж 2 | 1,100 Н-д хадаас нэвтрээгүй ба 1,100 Н-д давхаргууд нь салаагүй | * | Тэнцсэн |

Тэмдэглэгээ: * =туршилтын хадаасны үзүүр нь туршилтын хэсгийг нэвтэрч чадаагүй бөгөөд 1,100 Н-д давхаргууд нь салаагүй

3 Металл бус нэвтрэлтэд тэсвэртэй оруулганы химийн насжилтын туршилтын дараа хадаас нэвтр... байдал (EN 12568:2010, 7.2.1 & 7.4.5)

| Хүчлийн нөлөө (1 мол/l $H_2SO_4$ x 23 °c x 24 Цаг) | | | | |
|---|---|---|---|---|
| Дээж | Дээж | Хариу | Шаардлага | Тэнцсэн/ тэнцээгүй |
| - | Дээж 1 | 1,100 Н-д хадаас нэвтрээгүй ба 1,100 Н-д давхаргууд нь салаагүй | * | Тэнцсэн |
| | Дээж 2 | 1,100 Н-д хадаас нэвтрээгүй ба 1,100 Н-д давхаргууд нь салаагүй | * | Тэнцсэн |

Тэмдэглэгээ: * =туршилтын хадаасны үзүүр нь туршилтын хэсгийг нэвтэрч чадаагүй бөгөөд 1,100 Н-д давхаргууд нь салаагүй

*Intertek Туршилтын Үйлчилгээ Шенжен ХХК, Гуанжоу Салбар*

***Crystal Melody ХХК-ийн орчуулгын товчоонд орчуулж баталгаажуулав.***
***Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Silver бизнес мэдээллийн төв 2 тоот***
***Утас: 99942670, 99002885***
***Оффис: 70076677***

2024.06.22

4 Металл бус нэвтрэлтэд тэсвэртэй оруулганы химийн наслжилтын туршилтын дараа хадаас нэвтрэлтэнд тэсвэртэй байдал (EN 12568:2010, 7.2.1 & 7.4.4)

| Шүлтийн нөлөөлөл (1 мол/л NaOH x 23 °c x 24 цаг) | | | | |
|---|---|---|---|---|
| Дээж | Дээж | Хариу | Шаардлага | Тэнцсэн/ тэнцээгүй |
| - | Дээж 1 | 1.100 Н-д хадаас нэвтрээгүй ба 1.100 Н-д давхаргууд нь салаагүй | * | Тэнцсэн |
| | Дээж 2 | 1.100 Н-д хадаас нэвтрээгүй ба 1.100 Н-д давхаргууд нь салаагүй | * | Тэнцсэн |

Тэмдэглэгээ: * =туршилтын хадаасны үзүүр нь туршилтын хэсгийг нэвтэрч чадаагүй бөгөөд 1.100 Н-д давхаргууд нь салаагүй

5 Металл бус нэвтрэлтэд тэсвэртэй оруулганы химийн наслжилтын туршилтын дараа хадаас нэвтрэлтэнд тэсвэртэй байдал (EN 12568:2010, 7.2.1 & 7.4.6)

| Шингэн шатахууны нөлөө (2,2,4- Триметилпентан x 23 °c x 24 цаг) | | | | |
|---|---|---|---|---|
| Дээж | Дээж | Хариу | Шаардлага | Тэнцсэн/ тэнцээгүй |
| - | Дээж 1 | 1.100 Н-д хадаас нэвтрээгүй ба 1.100 Н-д давхаргууд нь салаагүй | * | Тэнцсэн |
| | Дээж 2 | 1.100 Н-д хадаас нэвтрээгүй ба 1.100 Н-д давхаргууд нь салаагүй | * | Тэнцсэн |

Тэмдэглэгээ: * =туршилтын хадаасны үзүүр нь туршилтын хэсгийг нэвтэрч чадаагүй бөгөөд 1.100 Н-д давхаргууд нь салаагүй



2021.06.22

*Англи хэлнээс хөрвүүлэв*

**ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ**

Гэрчилгээ: 70107240 Мастер гэрээ 268766

Дор дурдсан хамгийн сүүлийн хувилбарыг багтаасан жагсаасан бүтээгдэхүүнд лавлагаа Гэрчилгээнд нийцэх тэмдэглэгээ хийх эрхтэй болно.

Бүтээгдэхүүний Гэрчилгээжүүлэлтийн Түүх

| Төсөл | Огноо | Тодорхойлолт |
|---|---|---|
| 70107240 | 2017-01-03 | Ангилал 7232 01&81-Шинэ үйлдвэр "DEFU Гутлын материалын технологи ХХК"-ийн хамгаалалтын улны загвар "Flex-Tough"ийн шинэ гэрчилгээжүүлэлтийг IFE д гүйцэтгэв. (CSA Standard ZI 95-14 & ASTM 2413-11) |

***Crystal Melody ХХК-ийн орчуулгын товчоонд орчуулж баталгаажуулав***
***Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Silver бизнес мэдээллийн төв 2 давхар***
***Утас: 99942670, 99002885***
***Оффис: 70076677***

*Англи хэлнээс хорвуулэв*

CSA ГРУПП

# ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ

**Гэрчилгээ :** 70107240 **Мастер гэрээ:** 268766

**Төсөл:** 70107240 **Олгосон огноо:** 2017-01-03

DEFU ГУТЛЫН МАТЕРИАЛЫН ТЕХНОЛОГИ ХХК

Лонгвүржи цүн, Ванжианг Шекү

Донггуан, Гуангдонг 523000

ХЯТАД

Хэнд: Wayne Huang

Дор жагсаасан бүтээгдэхүүн нь хажуудаа ▲ заагчтай CSA тэмдгийг хэрэглэх эрхтэй болно.

/Тэмдгийн зураг/ /Тэмдгийн зураг/ олгосон James Hao Wang

БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД:

АНГИЛАЛ - C723201 –ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД- хамгаалалтын ул - Бүрэлдэхүүнийг хүлээн авах

АНГИЛАЛ - C723281 - ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙ, АЮУЛГҮЙ БАЙДЛЫН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД- хамгаалалтын ул - Бүрэлдэхүүнийг Нэгдсэн Улсын стандартад хүлээн авах

Металл бус хамгаалалтын ул: Flex-Tough

ХЭРЭГЛЭЖ БОЛОХ ШААРДЛАГУУД

CSA Стандарт Z195-14 – Хамгаалалтын гутал

ASTM F2413-11- Урд хоншоор хамгаалалттай гутлында зориулсан гүйцэтгэлийн шаардлагын стандарт тодорхойлолт

***Crystal Melody ХХК-ийн орчуулгын товчоонд орчуулж баталгаажуулав.***
***Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Silver бизнес мэдээллийн төв 2 тоот***
***Утас: 99942670, 99002885***
***Оффис: 70076677***

2021.06.22

/ЛОГО/ /ЛОГО/ /ЛОГО/

**ТУРШИЛТЫН ТАЙЛАН**

Туршилтыг хүсэлт гаргагчийн хүсэлтийг давуу явуулсан болно. Дугаар: GZHT90512588

1. Үрэлтэд тэсвэртэй байдал (ул) EN ISO 20344:2011(8.3), ISO 4649:2010, Арга A)

| | | | Шаардлага | Тэнцсэн/Тэнцээгүй |
|---|---|---|---|---|
| Хэмжээ 42 | Нягтаршил | Эвлэхүүний харьцангуй алдагдал | | |
| | 1.2 г/см3 | 129.9мм3 | | Тэнцсэн |

Тэмдэглэгээ: *=Нягтаршил:>0.9 г/см3, ХИ.150мм3

Өргөтгөсөн тодорхойгүй байдал: 1.76 мм3 K = 1.96-тай 95% -ийн итгэлцлийн түвшин

2. Шингэн шатахуунд тэсвэртэй байдал(ул) EN ISO 20344:2011(8.6.1), ISO 1817:2011, EN ISO 868:2003)

| | | Шаардлага | Тэнцсэн/Тэнцээгүй |
|---|---|---|---|
| Хэмжээ 42 | +11.55% | ХИ.+12%(*) | Тэнцсэн |

Тэмдэглэгээ:*=Хэрэв туршилтын мэсгийг хэмжээгээр нь 1%-иас илүү жижигрүүлэх эсвэл хатуулгийг 10 хязгаараас илүү нэгжээр нэмэгдүүлэх бол. Уян хатанг шалгах туршилтыг EN ISO 20344:2011,8.6.2-д тодорхойлсон аргын дагуу гүйцэтгэнэ.

Өргөтгөсөн тодорхойгүй байдал: 0.16%, K = 2.13-тай 95% -ийн итгэлцлийн түвшин

3. Гулсалтад тэсвэртэй байдал (EN ISO 20344:2011(5.11) & ISO 13287:2012, SRC [illegible]

| | | | Шаардлага | Тэнцсэн/[illegible] |
|---|---|---|---|---|
| Хэмжээ 42 | Баруун | Eurotile 2 дээр Nal.S | | |
| | | Өсгий урагшаа гулсах ( # 1): 0.40 | ХБ 0.28 | Тэнцсэн |
| | | Намхан өсгий урагшаа гулсах( # 2): 0.42 | ХБ 0.32 | Тэнцсэн |
| | | Глицеринтэй ган шалан дээр | | |
| | | Өсгий урагшаа гулсах ( # 1): 0.17 | ХБ 0.13 | Тэнцсэн |
| | | Намхан өсгий урагшаа гулсах( # 2): 0.20 | ХБ 0.18 | Тэнцсэн |

Тэмдэглэгээ: Энэхүү тайланд хийсэн гулсалтын эсэргүүцлийн туршилт нь туршилтын зүйлд дурдсан гадаргуу дээрх тухайн гутал / эд ангийн гулсалтын заалтыг илэрхийлж байгааг тэмдэглэх нь зүйтэй. Гутал нь өдөр тутмын хэрэглээний төрөл бүрийн нөхцөлүүдэд өртөмтгий бөгөөд гутлыг бүх нөхцөлд хальтирахад тэсвэртэй болгох боломжгүй гэдгийг анхаарах нь чухал юм. Гэсэн хэдий ч [illegible] удирдамжийн коэффициентэд хүрсэн тохиолдолд асуудлыг хамгийн бага түвшинд байлгахыг ерөнхийдөө хүлээн зөвшөөрдөг.

Тэмдэглэгээ:

#1- Стандарт гутал хийх аргыг ашиглах

#2-Механик гутлыг ашиглах

Өргөтгөсөн тодорхойгүй байдал: 0.01, K = 2.03-тай 95% -ийн итгэлцлийн түвшин

Intertek Туршилтын үйлчилгээ Shenzhen ХХК, Guangzhou Салбар

Блок E, 7-2, Кайпин зам, Гуанжоу шинжлэх ухааны хот, Гетдд Гуанжоу

Утас:+86 20 8213 9001 Факс: +86 20 8208 9909 Шуудангийн код: 510663

*Crystal Melody ХХК-ийн орчуулгын товчоонд орчуулж баталгаажуулав.*
*Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Silver бизнес мэдээллийн төв 2 тоот*
*Утас: 99942670, 99002885*
*Оффис: 70076677*

2024 [illegible]

*Англи хэлнээс хорвуулэв*

**INTERTEK** /Лого/ /Лого/ /Лого/

Бүх чанар баталгаажсан

ТУРШИЛТЫН ТАЙЛАН

Дугаар: GZHT91006863(S1)

Хүсэлт гаргагч:
DEFU ГУТЛЫН МАТЕРИАЛЫН ТЕХНОЛОГИЙН ХХК
LONGWUJI ТОСГОН WANJIANG ДҮҮРЭГ
DONGGUAN ХОТ

Огноо: 2020.12.09

Энэ тайлан нь 2020 оны 12 сарын 01-ний өдрийн GZHT91006863 тоот тайланг орлох болно.

Хэнд: RUBY

Дээжийн тодорхойлолт:

Илгээсэн 5 /таван/ дээж нь статикийн –эсрэг,металл бус,нэвчилтийн эсрэг, цагаан / улбар шар өнгийн оруулга гэв.

| | |
|---|---|
| Стандарт | EN 12568:2010 |
| Хүлээн авсан огноо / Туршилт эхэлсэн огноо | 2020.11.25 |
| Эцсийн мэдээг баталгаажуулсан огноо | --/ -- |
| Төлбөр хүлээн авсан огноо | |

Туршилтын хариуг Хавсралт хуудаснаас үзнэ үү.
Энэхүү тайлантай холбоотой асуулт байвал gzfootwear@intertek.com-тай холбогдож болно.

Зөвшөөрөл олгосон:

Intertek Туршилтын үйлчилгээ Шензен ХХК
Гуанжоу салбар
/гарын үсэг зурсан/
Лабораторийн ахлах менежер
Guiliang Dong

*Intertek Туршилтын үйлчилгээ Шензен ХХК Гуанжоу Салбар*

***Crystal Melody ХХК-ийн орчуулгын товчоонд орчуулж баталгаажуулав.***
***Хаяг: Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Silver бизнес мэдээллийн төв 2 тоот***
***Утас: 99942670, 99002885***
***Оффис: 70076677***

Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хорооны
2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

# АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛГҮЙ ГЭДГЭЭ ИЛЭРХИЙЛЭХ, ЗӨРЧИЛ ҮҮССЭН ТУХАЙ МЭДЭГДЭЛ

**Нэг. Нийтийн албан тушаалтан**

| | | |
|---|---|---|
| **Ургийн овог**: Олхонууд | **Эцэг (эх)-ийн нэр**: Норовсамбуу | **Нэр**: Удаанжаргал |
| **Албан тушаал:** Гүйцэтгэх захирал | | **Ажиллаж байгаа байгууллага:** Тавантолгой төмөр зам ХХК |
| **Албан тушаалд томилогдсон он, сар, өдөр:** ТУЗ-ийн 2018.12.04-ний өдрийн 02 дугаар тогтоол | | **Байгууллагын хаяг:** Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Юнион бюлдинг, "B" блок, 11-р давхар. |
| **Албан үүргийн төрөл:** Гэрээ байгуулах. | **Тайлбар**: Богдхан төслийн "Хөдөлмөр хамгааллын өвлийн гутал" худалдан авах гэрээг "Бест шуес"ХХК-тай байгуулахад ашиг сонирхлын зөрчилгүй болно. | |

Сонирхлын зөрчилтэй эсэх Тийм ☐ Үгүй ☑

**Хоёр.Сонирхлын зөрчилгүйг илэрхийлсэн байдал**

Нийтийн албан тушаалтан ______________________________
би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэхэд Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд заасан сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

**Гурав.Сонирхлын зөрчил үүссэн тухай**

Нийтийн албан тушаалтан би дээрх хүснэгтэд тодорхойлсон албан үүргээ гүйцэтгэх хүрээнд:

☐ гаргах, гаргахад оролцох шийдвэр нь хамаарал бүхий этгээдтэй холбоотой гэх /хувь хүн, хуулийн этгээдийн нэр, үйл ажиллагааны чиглэл/:

______________________________

☐ гэрээ хэлцэл, хэлэлцээрийн оролцогч, эсхүл зээл, хандив, тусламж, үйлчилгээг хувь хүн, хуулийн этгээдээс авч байсан /байгаа/-тай холбогдуулж үүрэг хүлээсэн гэх:

______________________________

☐ байгууллага, хуулийн этгээдэд ажиллаж байсан, гишүүнчлэлтэй, эсхүл төлөөлөл хэрэгжүүлж байсан /байгаа/ гэх:

______________________________

☐ Бусад /сонирхлын зөрчилтэй бусад нөхцөл байдал/:

______________________________

нөхцөл байдал бий болсон гэж үзэж Нийтийн албанд нийтийн болон хувийн сонирхлыг зохицуулах, сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэгт заасны дагуу сонирхлын зөрчил үүссэнийг мэдэгдэж, албан үүргээ гүйцэтгэхээс татгалзаж байна.

**Дөрөв.Баталгаажуулалт**.

Би нийтийн албан хаагчийн үүргээ чанд ухамсарлан энэхүү мэдэгдлийг үнэн зөв гаргасан болохоо үүгээр баталгаажуулж байна.

| Гүйцэтгэх захирал: /албан тушаал/ | ........................................ /гарын үсэг/ | Н.Удаанжаргал /гарын үсгийн тайлал/ |
|---|---|---|

2022 он 09 сарын 21 -ны өдөр

---

**Шийдвэрлэсэн байдал**

Ашиг сонирхлын зөрчил үүссэн тохиолдолд албан тушаалтныг албан үүргээ гүйцэтгэхийг зөвшөөрөх эсэх ☐ Тийм ☐ Үгүй

Хэрэв "Тийм" бол шалтгааныг тэмдэглэнэ үү.

☐ Тухайн албан үүргийг гүйцэтгэх өөр албан тушаалтан байхгүй

☐ Дээд шатны байгууллагаас өөр албан тушаалтан томилон ажиллуулах боломжгүй

☐ Мэргэжлийн өндөр мэдлэг, ур чадвар шаардагдсан албан тушаалтан байхгүй

Баталгаажуулалт:

............................................................: ..............................................  /..................................../
/албан тушаал/ /гарын үсэг/ /гарын үсгийн тайлал/

... он ... сар ... өдөр